



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/99

Бөхт

“Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023-2024 оны Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 279 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/459 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ажлын явцад хяналт тавих хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг 2023 оны 10 сарын 10-ны дотор, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2023 оны 10 дугаар сарын 15-ны дотор хангаж, тайлан мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Мөнхбадрах), (Б.Амгаланжаргал) нарт даалгасугай.

3. Малчид, иргэд, төрийн байгууллагын удирдлага, аж ахуй нэгжүүдэд өвөлжилтийн бэлтгэлийг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр  
сарын 11-ний өдрийн А/99 дүгээр  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН  
БЭЛТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч  
Нарийн бичгийн дарга  
Гишүүдэд

Л.Мөнхбадрах - Сумын Засаг даргын орлогч  
Х.Уугандорж - Хөдөө аж ахуй мэргэжилтэн  
Х.Хундмаа – Санхүүгийн албаны дарга  
Э.Сумъяа -1 дүгээр багийн Засаг дарга  
Д.Шинэбаяр - 2 дугаар багийн Засаг дарга  
Б.Мядагмаа - Мал эмнэлгийн тасгийн  
мэргэжилтэн



Сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр  
сарын 11-ний өдрийн А/99 дүгээр  
захирамжийн 2 дугаар хавсралт

ТӨВ СУУРИН ГАЗРЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛИЙГ  
ХАНГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч  
Нарийн бичгийн дарга  
Гишүүдэд

Б.Амгаланжаргал ЗДТГ-ын дарга  
Х.Хундмаа Санхүүгийн албаны дарга  
Т.Мөнхцэцэг Соёлын төвийн дарга  
Д.Номин-Эрдэнэ- Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч  
Д.Эрдэнэчулуун Эрүүл мэндийн төвийн дарга  
Н.Дэлгэрсайхан – ЕБС-ийн  
М.Цэвэгдорж - 3 дугаар багийн Засаг дарга  
Ө.Эрдэнэбаатар Ирмүүн түшиг ХХК-ны инженер